

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛҮЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“УЛААНГОМЫН ДУЛААНЫ ХОЁРДУГААР СТАНЦ”ТӨХК-ИЙН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б. АНХБАЯР



БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

РД 4012534

ХЯНАСАН:

БОГ-ЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, УУЛ УУРХАЙН АСУУДАЛ

ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

А. ПҮРЭВСОСОР

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН :

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ

БАЙДЛЫН ИНЖЕНЕР

Ү. МАРТ

2026 он

Агуулга

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн байршил, орчны тойм зураг

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Төслийн нэр

2.2 Төслийн зорилго

2.3 Төсөл хэрэгжүүлэгч

2.4 Төслийн талбайн байршил

2.5 Төслийн хүчин чадал

БҮЛЭГ 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХУРААНГУЙ

3.1 Зорилт

3.2 БОМТ –ий зардлын хураангуй

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

4.2 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

4.3 Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө

4.4 Осол, эрсдлийн төлөвлөгөө

4.5 Ажилчдын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах

4.6 Удирдлага –зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө

4.7 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө

4.8 Орчны хяналт шинжилгээний хяналт шинжилгээний хөтөлбөр

ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

“УЛААНГОМЫН ДУЛААНЫ ХОЁРДУГААР СТАНЦ”ТӨХК-ийн үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн хүн, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоосон бөгөөд энэхүү 2026 оны БОМТ нь 2024 онд батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн 3 дахь жилийн БОМТ юм.

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн байршил, орчны тойм зураг

“УЛААНГОМЫН ДУЛААНЫ ХОЁРДУГААР СТАНЦ”ТӨХК нь Увс аймгийн Улаангом сумын 5-р багийн нутагт үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд дэд бүтцийн байгууллагын зориулалтаар нийт **22280м² талбайд 2015 оны 08 сарын 27 өдрийн А/472 тоот шийдвэрээр 15 жилийн хугацаатай эзэмшүүлэх эрхийн гэрчилгээтэй.**



Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Төслийн нэр

“ Хэрэглэгчийг дулаан, хэрэглээний халуун усаар хангах” төсөл

2.2 Төслийн зорилго

Увс аймгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн өсөлтийг хангахуйц дулааны эрчим хүчний бодлогыг хэрэгжүүлж дулаан хангамжаар хүний эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах болон үйлдвэрлэл, үйлчилгээний найдвартай тогтвортой ажиллах нөхцөлийг хангахад оршино.

2.3 Төсөл хэрэгжүүлэгч

“Улаангомын дулааны хоёрдугаар станц”ТӨХК

Улсын бүртгэлийн дугаар – 1514001006

ААН-н регистрийн дугаар – 4012534

2.4 Төслийн талбай

“Улаангомын дулааны хоёрдугаар станц”ТӨХК нь Улаангом хотоос зүүн урд зүгт, **Цэдэнбалын талбайгаас 1 км зайтай байрладаг.**



Зураг 2. Төслийн талбайн зураг

2.5 Төслийн хүчин чадал

“Улаангомьын дулааны хоёрдугаар станц”ТӨХК нь 35 МВт хүчин чадал бүхий 2014 онд суурьлагдсан КВ-Ф-11,63-115 маркийн 3 зуухтай.

Зуух тус бүр “ВДН-8,5Х-1-3000” маркийн үлээх салхилуур, “ДН-15Х-1000” маркийн утаа сорогчтой, “ПМЗ-600ЧЛЦ” маркийн хоёр нүүрс шидэгчтэй ба үнс барих төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон. 2025-2026 онд К-1,2,3 зуух ажиллаж, 14 дулаан дамжуулах төвөөр хэрэглэгчидийг дулаан, хэрэглээний халуун усаар тасралтгүй найдвартай хангаж байна. Дулааны төв шугамын урт 4,7км.

2024-2025 оны халаалтын улиралд 36,331тн нүүрс зарцуулж, 92,327ГКал дулаан үйлдвэрлэсэн.

2025-2026 онд төслийн талбайн байршлыг 7000м²-аар нэмэгдүүлэн 23 мВт-ын хүчин чадал бүхий зуухны өргөтгөлийн ажил хийж үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлж байна.

БҮЛЭГ 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХУРААНГУЙ

3.1 Зорилт

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгууллага орчмын нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, байгууллагын орчмын орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн бичиг баримт юм.

Байгаль болон ажилчдын эрүүл мэндийг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс жилийн БОМТ бүрдэнэ. Төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт үйлдвэрийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгасан.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
- Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө
- Осол, эрсдлийн төлөвлөгөө
- Ажилчдын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах

- Удирдлага –зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө
- Орчны хяналт шинжилгээний хяналт шинжилгээний хөтөлбөр

3.2 БОМТ –ий зардлын хураангуй

“УЛААНГОМЫН ДУЛААНЫ ХОЁРДУГААР СТАНЦ” ТӨХК нь 2026 оны БОМТ-г компанийн гүйцэтгэх захирлын 2025 оны 07-дугаар сарын 18-ны өдрин А/42 тушаалын хавсралт болон Байгаль орчин аялал жуулчлалын яамны сайдын 2019 оны 10-дүгээр сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3-р хэсэгт заасны дагуу боловсруулав.

2024 онд батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд БОМТ-г хэрэгжүүлэх 5 жилийн зардлын дундажаар жилд хэрэгжүүлэх төлөвлөгөөний зардлыг 13,812,000₮ төсөвлөсөн ба 2026 оны БОМТ-г хэрэгжүүлэхэд нэмэлтээр үйл ажиллагааны болон төсвийн зардлаар санхүүжүүлнэ.

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга зам	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хугацаа	Зардал	Баримтлах хууль, журам, стандарт, аргачлал
1	2	3	4	5	6
Тоосжилт үүсэх, хөрсөн бүрхэвч бохирдох, элэгдэх эвдрэх	Нүүрс буулгах талбайн нөхцлийг сайжруулах тоосжилтыг тархахаас сэргийлэх хашаа барих	Агаарын чанар	2025-2026 он	Төслийн зардлаар	- Агаарын тухай хууль - MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. - Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын бүсийн агаар дахь хорт бодисын концентрацийг хэмжих аргачлалд тавих шаардлага MNS 4991:2000 -“Үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага MNS 5078:2001
	Агаарын шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, түвшинг тодорхойлуулан, заавар зөвлөмж авч ажиллах		Агаарын шинжилгээг жилд 2 удаа хийлгэх	89,000	
Хийн хаягдал, тоосжилт	Орчны агаараас дээж авч, мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэж, түвшинг тодорхойлуулан, заавар зөвлөмж авч ажиллах				
Ус ашиглалт	Усны төлбөр төлөх	Усны нөөц хэмнэх	Тоолуурын заалтаар	7500төг/м ³	-Усны тухай хууль, - Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам, -Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль
	Гүний усны худагт тусгай зөвшөөрөл авах		1-р улиралд	Үйл ажиллагааны зардлаар	
Тоосжилт, Хөрсний элэгдэл, эвдрэл	Сул чөлөөтэй талбайг тарималжуулж, ногоон байгууламж байгуулах	Агаарын чанарт хөрс, ургамлан нөмрөг	5-6 сард	Ажилтан бүр 1-2 ш мод тарих	Хөрс хамгаалал, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

Ургамлан нөмрөг талхлагдах, хөрсөн бүрхэвч бохирдох	Эзэмшил газрын хог хаягдлыг цэвэрлэх, эвдэрсэн хөрсийг засаж тэгшлэх.	Хөрс, ургамлан нөмрөг	Улирал бүр	Үйл ажиллагааны зардлаар	
Газар доорх усны чанар, хүн амын эрүүл мэнд	Үнсэн сангийн үнсийг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан, тэдгээрт нийцүүлж байх.	Агаарын чанар	Жил бүр	Гэрээний тарифийн дагуу	
Хөрс элэгдэх, Ургамлан нөмрөг талхлагдах	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхдээ сумын ТҮК-тай гэрээ байгуулах	Хог хаягдлын менежмент	1-р сард	Гэрээний тарифийн дагуу	MNS 5344:2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага
БОННУ-ний хэрэгжилтийн тайлагнах.	тайлангийн талаар нутгийн иргэдэд	Олон нийтийн оролцоо, хяналтыг хэрэгжүүлэх	2-р улиралд	БОМТ-ий зардлаар	БОНХЯ-ны сайдын 2014 оны 1-р сарын 06-ны өдрийн А-03 тоот журам

2. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга зам	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хугацаа	Зардал	Баримтлах хууль, журам, стандарт, аргачлал
Ахуйн болон химийн	Ахуйн хог хаягдал түр хадгалах сав байгуулах, хог түр хадгалах цэгт цугларсан хогийг тогтмол хугацаанд зөвшөөрсөн цэгт тээвэрлүүлж байх.	Үйлдвэрийн хашаа	Сар бүр	Гэрээнд тусгагдсаны дагуу	-“Хог хаягдлын тухай хууль”, -“Хог хаягдлын тухай хууль”

аюултай хатуу хог хаягдал	Химийн бодисын сав баглаа боодлыг хүлээн авсан, хүлээлгэн өгсөн мэдээллийн сан, бүртгэл үүсгэх	Төслийн хүрээнд	1-р улиралд	-	- MNS 5344:2003 - БОАЖС-ын 2018 оны А/428 дугаар тушаалаар батлагдсан “Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журам”
Хог хаягдал хуримтлагдах	Байгууллагын талбай орчныг бохирдуулахаас сэргийлж, холбогдох байгууллагатай хамтран ойр орчимд тогтмол цэвэрлэгээ хийх.	Ойр орчмын 50 метр газарт	Тухай бүр	-	
Удаан задардаг хатуу хог хаягдал үүсэх	Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид нийлүүлэх.	Төслийн хүрээнд	Тухай бүр	-	
Ялаа шавж үржих, өвчин гарах	Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдлоос сэргийлэх.	Хатуу хог хаягдлын цэгт	2,3-р улиралд	Үйл ажиллагааны зардлаар	

3. Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Зардал	Хугацаа, давтамж	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
Химийн бодисын ашиглалт, хадгалалтын үе шат				
Химийн бодисын хадгалалт, ашиглалтын явцад асгарах, хадгалалт хамгаалалтын дүрэм алдагдсанаар ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Химийн бодистой ажиллах ажиллагсдыг хувийн хамгаалах хэрэгслээр бүрэн хангах.	ХАБ-ын зардалд тусгасны дагуу	Батлагдсан нормын дагуу	- Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль - Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам - MNS 5029:2011 - MNS 6458:2014 - MNS/ISO/ 13688:2000
	Ажилчдад химийн бодистой харьцаж ажиллах зааварчилга, сургалт явуулах.	-	Жилд 2-оос доошгүй удаа	
	Ажлын байранд эмийн сангийн баяжуулалт хийх .	ХАБЭА-н зардалд тусгагсны дагуу	Улирал бүр	

Ослын эрсдлээс урьдчилан сэргийлэх					
ХБ-ын агуулахын битүүмжлэл алдагдаж, агаар, ус хөрсөөр тархах, ХБ-ын ашиглалтын үед асгарч алдагдах	ХБ-т өртсөн үед яаралтай тусламж үзүүлэх хэрэгсэл, эмийн сан бий болгож, тодорхой газар байрлуулах.	-		Тогтмол	- Гамшгаас хамгаалах тухай хууль - Галын аюулаас урьдчилан сэргийлэх заавар
ХБ-ын агуулах болон лабораторит гал гарах	Лабораторийн өрөөг галын аюулын эсрэг хэрэгслээр хангах. /галын хор, элс, хүрз, г.м/	ГАБ-ын зардалд тусгасны дагуу			

4. Осол, эрсдлийн төлөвлөгөө

Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хугацаа	Зардал	Баримтлах хууль, журам, стандарт, аргачлал
1	2	3	4	5	6
Гэнэтийн болзошгүй осол эрсдэл					
Аянга цахилгаан	ДС-ын цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг бүгдийг нь стандартын дагуу газардуулсан байх.	Станцын байр болон ДДТ-д	Тухай бүр	Төсвийн зардлаар	Цахилгаан техникийн байгууламжийн угсралтын ажлын АА-ы дүрэм
Аадар бороо	Барилга байгууламжуудын зураг төсөл, чанарт цаг агаарын нөхцлүүдийг тусгах, үерээс хамгаалсан далан байгууламжтай болгох.		2,3-р улиралд		-

5. Ажилчдын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах

Ажилчдын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хугацаа	Хамрагдалт	Зардал	Баримтлах хууль, журам, стандарт, аргачлал	
Бүх ажиллагсдыг мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон хугацаат эрүүл мэндийн үзлэгт хамруулах.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	Жил бүр	97 ажилчид	11,640 сая	- ХАБЭА-н тухай хууль - ХАБЭА-н сургалт зохион байгуулах - MNS 4969:2000	
Хөдөлмөр аюулгүй байдлын сурталыг тогтмол хийж байх, "Хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилга"-тай ажилчид танилцаж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж хэвшүүлэх.		Тогтмол	Бүх ажилчид	-		
Ажилчдад өглөө бүр АА-ы зааварчилгааг өгч гарын үсэг зуруулан баталгаажуулж ажилтныг аюулгүй ажиллах арга барилд байнга сургах.		Үйлдвэрлэлийн ажилчид	-			
Ажлын байрны гэрэлтүүлгийг жигд хүрэлцээтэй тусаж байхаар ерөнхий болон хэсгийн гэрэлтүүлгийг сайжруулах.		Тухай бүр	-	Үйл ажиллагааны зардалд тусгах	Хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ MNS 5080:2001	
Үйлдвэрлэлийн эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл түүний ангилал, хүчин зүйл, хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ MNS 5080:2001 стандартыг мөрдөж ажиллах.		Тогтмол	Бүх ажлын байр	2025 онд зөөврийн багажнууд авсан байгаа		

6. Удирдлага –зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Зардал	Хугацаа	Хариуцах албан тушаалтан	Тайлбар
1	Ажилчдыг ажлын тусгай хувцас, хувийн хэрэгслээр бүрэн хангах.	ХАБ-ын зардалд тусгагдсаны дагуу	Батлагдсан нормын дагуу	Ажил олгогч	<ul style="list-style-type: none"> - ХАБЭА-н хууль - ГАБ-ын тухай хууль
2	Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах. Ажилчдыг ажлын онцлогоос хамааруулан хувийн хамгаалах хэрэгслээр тогтмол хангах, хордлого тайлах хүнс, эмээр хангах.				
3	Галын аюулаас хамгаалах хэрэгсэл, эрүүл ахуйн хэрэгслээр хангах.		Жил бүр		
4	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ-д хүргүүлэх.	-	Жил бүр	ХАБ-ын инженер	Төлөвлөгөөний дагуу хийсэн ажлаа тайлагнах.
5	Газар, ус, цахилгаан ашигласны болон бусад төлбөр төлөх.	Төсвийн зардлаар	Сар бүр	Санхүү алба	Гэрээний биелэлт хангах
6	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг жил бүр боловсруулж батлуулах .	-	Жил бүр	ХАБ-ын инженер	БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу
7	Төслийн талбай орчмын иргэдийн санал хүсэлтийг харгалзан сумын иргэдэд тулгамдаж буй асуудлыг шийдэж өгөхөд дэмжиж туслах, нийгмийн хариуцлагын гэрээ байгуулах.	-	2-р улиралд	Төсөл хэрэгжүүлэгч	Нийгмийн хариуцлагын хүрээнд
8	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхдээ аймгийн ТҮК-тай хийсэн гэрээний дагуу зайлуулах	Гэрээнд тусгагдсан төлбөр	Сар бүр	ХАБ-ын инженер	<ul style="list-style-type: none"> - Хог хаягдлын тухай хууль - MNS 5344:2003
9	Байгаль орчны аудит хийлгэх	30 сая	1 –р улиралд	Төсөл хэрэгжүүлэгч	БОННУ-нд тусгагдсаны дагуу

7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээ					
БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацаа	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	“БОНХЯ-ны сайдын 2014 оны 1-р сарын 06-ны бдрийн А-03 тоот журам” Олон нийтийн оролцоо, хяналтыг хэхэгжүүлэх хүрээнд
Байгаль орчны газар	Шинжээчийн дүгнэлтээр баталгаажна.	БОМТ-ний биелэлтийн тайлан	Жил бүрийн 11-р сард	Шинжээчийн дүгнэлт	
Бүх шатны Засаг дарга, байгаль орчны улсын байцаагч	Хуралд танилцуулах, уулзалт	БОМТ-ний тухайн жилийн тайлан	12-р сарын 1-ний дотор	БОХ арга хэмжээний тайлан, ирэх оны төлөвлөгөөг танилцуулах, санал авах, хамтран ажиллах	
Орон нутаг, төрийн бус байгууллагууд, олон нийт			Жилд 1 удаа		
Төрийн захиргааны төв байгууллага	Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр	Ирэх жилийн төлөвлөгөө	12-р сарын 10-ны дотор	Хянуулах батлуулах	

8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа, давтамж	Зардал	Хамтран хэрэгжүүлэгч	Баримтлах журам, норм стандарт
Агаар орчны хяналт шинжилгээ							
1	Хорт хийн агууламж: Азотын давхар исэл (NO ₂ , NO, NO _x) Хүхэрлэг хий (SO ₂) Нүүрстөрөгчийн дутуу исэл CO ₂ , CO, HCN, O ₂	мкг/м ³	Үнсэн сангийн зүүн урд-1 Нүүрсний талбайн зүүн урд талд талбай	Жилд 1-ээс багагүй удаа	150,000	Мэргэжлийн байгууллага, судлаач	УСТ 3384-92 УСТ 3600-83 MNS 4048-1988 MNS 4585-2016 MNS ISO 4227-2002 MNS 3113-1981 MNS 5028-2001
2	Агаарын тоос тоосонцор (PM _{2.5} , PM ₁₀)	МКМ					

			дотор-1, гадна-1 Нийт -3 цэг				
3	Халаалтын зуухнаас гарсан хаягдал үнснээс шинжилгээ авах	мкм	Үнс түр хадгалах цэгээс		200,000		
4	Хаягдал үнсний цацрагийн хэмжилт						
Усан орчны чанарын хяналт шинжилгээ							
1	Лагийн шинжилгээ хийлгэх	мг/л	Бохир ус	Жилд 1-ээс багагүй удаа	200,000	Газарзүй, гео-экологийн хүрээлэнгийн усны лаборатори, УЦУОШГ	MNS 900:2005
Хөрсөн бүрхэвчийн хяналт шинжилгээ							
1	Хөрсний физик, агрохимийн үндсэн үзүүлэлтүүд: Хөрсний морфологи бичиглэл, Рн, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO ₃ , P ₂ O ₅ , K ₂ O)	мг/кг %	Нүүрсний талбай, үнсэн сан орчимд	Жилд 1-ээс багагүй удаа	60,000	Газарзүй, гео-экологийн хүрээлэнгийн усны лаборатори, УЦУОШГ	УСТ 3297:2019 MNS 5850:019 MNS ISO 10390:2001 MNS(ISO)11260:2000 MNS ISO11269-1:2000 MNS 5546:2005 MNS 3298:1991 MNS 3245:1989 MNS 5918:2023

9.2 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал /таван жилээр/

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний таван жилийн дундаж зардлыг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 58. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

Зардлын хэлбэр	Хугацаа, он /мян.төг/
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	30,160,000
Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө	3,400,000
Осол, эрсдлийн төлөвлөгөө	1,100,000
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,250,000
Орчны хяналт шинжилгээний зардал	13,150,000
Удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө	20,000,000
5 жилд	69.060.000

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 5 жилийн нийт зардал **69.060.000** төгрөг болно. 2024 оны 1-р улиралд БОННУ тайлан болон БОМТ-г батлуулах, тайлангнах ажил хийгдэнэ.